**ХУУЛЬЧИД “БИД”**
**ХАМТДАА ХҮЧТЭЙ**

# МӨРИЙН ХӨТӨЛБӨР

*Монголын Хуульчдын холбооны*
*Ерөнхийлөгчид нэр дэвшигч, Хууль*
*зүйн ухааны доктор П.Одгэрэл*

**Нэг.Холбоог бэхжүүлэх чиглэлд:**

**1.**ХЭЗБтХ-ийн 49.1 дэх хэсгийн “Хуульчдын холбоо чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ” гэсэн зохицуулалтын хүрээнд хороодын зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгож, илүү үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Сайн дурын гэж нэрлэгдсэн салбар эрх зүйн хороог заавал гишүүнчлэлтэй, “мэргэшлийн хороо” болгон хөгжүүлнэ. Хуульчийг салбар эрх зүйн хороонд заавал гишүүнчлэлтэй байх шаардлага нь нэмэлт татвар, хураамж бий болгох үндэслэл болохгүй бөгөөд хуульчдыг мэргэшүүлэх, мэргэшсэн хуульчдыг дэмжих үндсэн зорилгыг агуулна.

**2.**ХЭЗБтХ-ийн 32 дугаар зүйлд заасан “Мэргэшсэн хуульч”-ийн талаарх зохицуулалтыг амилуулж хэрэгжүүлнэ. Хуульчдыг мэргэшиж ажиллах бүх талын боломж нөхцөлөөр хангана. Мэргэшсэн хуульчийн гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулна.

Хуульчийг мэргэшүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулах, дүгнэх, шинэчлэн сайжруулах ажлыг болон мэргэшсэн хуульчийн гэрчилгээ олгох асуудлыг салбар эрх зүйн хороодод хариуцуулна.

Мэргэшсэн хуульч, өмгөөлөгчийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах ажлыг тогтмол зохион байгуулна. Орчин үеийн хуулийн практик хэрэглээ бүх хуульчдыг тодорхой салбарын хуулиар мэргэшихийг шаардаж байгаа тул анхаарахгүй орхиж боломгүй юм.

**3.**ХЭЗБтХ-ийн 45 дугаар зүйлд заасан Хуульчдын холбооны “хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх” үндсэн чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлнэ. Мэргэшсэн болон мэргэших сонирхол бүхий хуульчдыг нэгтгэсэн салбар эрх зүйн хороодыг хууль зүйн бодлогын асуудлаар “хамаарах” УИХ-ын байнгын хороо, Засгийн газрын яам, агентлагтай чөлөөтэй харилцаж, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Үүний хүрээнд мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хуульчдын байр суурь, санал, зөвлөмж, судалгааг харгалзан үзэж тусгадаг соёл, зүй ёсны хамтын ажиллагааг бий болгоно.

**4.**ХЭЗБтХ-ийн 45 дугаар зүйлд заасан Хуульчдын холбооны “Шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх” үндсэн чиг үүргийг тогтмол хэрэгжүүлнэ. Үүнтэй уялдуулж, ХЭЗБтХ-ийн 59.5 дахь хэсэгт заасны хүрээнд хараат бус, хууль зүйн судалгааны бүтцийг Хуульчдын холбооны дэргэд байгуулж, ажиллуулна.

Судалгааны бүтэц нь салбар эрх зүйн хороодын үйл ажиллагаан дээр үндэслэх бөгөөд тус хороодын санал, санаачлага, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжоор хангана. Түүнчлэн хуулийн магистр, доктор болон бусад судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

**ХУУЛЬЧИД "БИД"**
**ХАМТДАА ХҮЧТЭЙ**

Судалгааны бүтэцтэй хамтатган нийт хуульчид үнэ төлбөргүйгээр чөлөөтэй ашиглах номын сан (цахим номын сан) байгуулна. Судалгааны бүтэц, номын сангийн ажиллах орчин, нөхцөлийг цогцоор нь төлөвлөж, шийдвэрлэнэ. Судалгааны бүтцийн үйл ажиллагааны санхүүжилт болон гадаад харилцаан дээр анхаарч ажиллана.

**5.**ХЭЗБтХ-ийн 59 дүгээр зүйлийн хүрээнд Хуульчдын холбооны үйл ажиллагаанд маш чухал ач холбогдолтой Зөвлөхүүдийн зөвлөлийг байгуулж ажиллуулна.

Зөвлөхүүдийн зөвлөл нь "Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан хуульчдаас бүрдэх" хууль зүйн тодорхой шаардлагатай бөгөөд энэхүү зөвлөлийг бүрдүүлэхдээ хуульчдын саналыг харгалзан үзэх журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

**6.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг цаг алдахгүйгээр батлуулж, хэрэгжүүлэх тал дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж, хуульчдын холбоог бэхжүүлэх, үйл ажиллагааны үр дүн, цар хүрээг нэмэгдүүлэх, гишүүн хуульчдад тулгарсан хүндрэлтэй асуудлуудыг зөв зохистойгоор шийдвэрлэх ач холбогдол бүхий зохицуулалтуудыг хуульд тусгуулах арга хэмжээг авна.

**Хоёр.Үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд:**

**1.**Холбооны үйл ажиллагаа**,** үйлчилгээг бүрэн цахимжуулж, цаг хугацаа орон зайнаас үл хамааран хуульчид хоорондоо хамтран ажилладаг дэд бүтцийг байгуулна. Энэхүү цахим дэд бүтцийг ашиглаж, хуульч бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, түүнийгээ нийт хуульчдад хүргэж танилцуулдаг, санал шүүмжлэл, мэтгэлцээн өрнүүлдэг, хэлэлцүүлэг зохион байгуулдаг, түүнийх нь үр дүнд тодорхой шийдэл, үр дүн гарч хэрэгждэг дэг, соёл, журмыг бий болгоно.

Хуульчид бид хуулийн алдаа оноог тал бүрээс нь өөрсдийн бие дээр мэдэрч, засаж залруулах талын санал, шийдлийг байнга бодож, боловсруулж явдаг онцлогтой хүмүүс. Иймд хуульчдынхаа хүрээнд санал солилцох, мэтгэлцэх, хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг үйл ажиллагааны албан ёсны байдлыг хангах хялбар цахим системийг бий болгон хэрэглээнд нэвтрүүлж, хууль зүйн бодлогын асуудлаарх хуульчдын санал, шүүмжлэл, шийдлийг УИХ болон Засгийн газарт шуурхай хүргэдэг болгоно.

**2.**Хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтын агуулга, хөтөлбөрийг хуульчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлж төрөлжүүлнэ. Сургалтыг "Суурь сургалт (шинэ хуульчдад зориулсан), Мэргэшүүлэх сургалт (ахисан шатны), Практик сургалт (3-аас дээш жил ажилласан хуульчдад зориулсан)" гэсэн 3 төрөлд ангилан, тухайлан боловсруулсан үр дүнтэй сургалтын хөтөлбөрөөр явуулж, багц цагийг онцлог бүрт нь тохируулж, оновчтойгоор тооцож явах болзол, журмыг нэвтрүүлнэ.

"Практик сургалт" нь хуульчдын баримталж буй хууль зүйн бодлогын асуудал, олон талт судалгаа, оролцоонд үндэслэх бөгөөд 1 жилийн кредитийн 50 хүртэлх хувиар багц цагийг тооцно. Хуульч нь тодорхой хуулийн асуудал дээр зохих судалгааг хийж, үндэслэл бүхий санал, шүүмжлэл дэвшүүлэн, хуульчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан мэтгэлцэж, тодорхой үр дүнд хүрсэн идэвхитэй ажиллагааг явуулжан өөрийн мэдлэг чадвар болон бусад хуульчдынхаа мэдлэгт хөрөнгө оруулж байгаа нь "практик сургалт" юм. Үүний хүрээнд хуульчдын оролцоо бүрийг үнэлж, кредит цаг тооцдог болох бүрэн боломжтой бөгөөд энэ харилцааг зохицуулсан журмыг холбооны зөвлөлөөр батлуулж, хэрэгжүүлнэ.

**ХУУЛЬЧИД "БИД"**
**ХАМТДАА ХҮЧТЭЙ**

Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг практик сургалтын үр дүнтэй уялдуулж, салбар эрх зүйн хорооны оролцоотойгоор боловсруулж, хэрэгжүүлдэг болгоно.

**3.**Холбооны орлого, зарлага, хадгаламж, санхүүгийн мэдээллийг ил тод болгож, шилэн дансны тогтолцоо, журмаар ажилладаг болгоно.

**4.**Шүүх, прокурор, нотариат, өмгөөллийн байгууллагын цахим үйлчилгээг дэмжиж, хуульчдын эрх ашиг, оролцоог хангах шаардлага, нөхцөлийн хүрээнд хамтран ажиллана. Тухайлбал Шүүх эрх мэдлийн байгууллагаас хэрэгжүүлэхээр баталсан "Цахим шүүх" бодлогын концепцийг бүх талаар дэмжиж, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулахад Холбооны болон хуульчдын дэмжлэгийг чиглүүлнэ.

**5.**Орчин үеийн хөгжил, дэвшлээс хоцрохгүй байх, түрүүлж алхах, шинэ мэдлэг, бодит мэдээллээр тухай бүр хангагдах боломжийг нийт хуульчиддаа бүрдүүлж өгөхийг зорино.

**Гурав.Хуульчдын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд:**

Хууль тогтоогчдын баталсан буруу, алдаатай хууль буюу улс төрийн зохисгүй шийдвэрийн хариуцлагыг шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульч нар маань хүлээдэг боллоо.

Хуульчид бол хуулийг хэрэгжүүлэх л үүрэгтэй. Бидний хувьд буруу хууль гэсэн ойлголт байдаггүй. Хамгийн харамсалтай нь иргэд, олон нийтийн зүгээс буруу, алдаатай хуулиас үүдэн гарсан шударга бус байдлын хариуцлагыг хуульч нараас нэхэж, нийтээр нь буруутгах хандлага бий болж байгаатай хуульчид бид огтхон ч эвлэрч болохгүй юм.

Шүүгч, өмгөөлөгч эсвэл прокурор дангаараа энэ хариуцлагаас мултарч нэр цэвэр гарах боломжгүй. Иймд хуульчид бүгдээрээ нэгдэж, шударга ёсны төлөө, шударга хуулийн төлөө, хуулийг шударгаар хэрэгжүүлэхийн төлөө илүү хүчтэй, илүү нягт хамтран ажиллахаас өөр сонголтгүй байна. Энэ хуульчдын хамтын ажиллагааг зохион байгуулж хуульчдын нэр хүндийг сэргээх, нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нь Монголын Хуульчдын холбооны үндсэн хийх ажил юм.

---oOo---